

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Орчин үеийн стантарт бүхий спорт байгууламжийг байгуулж, иргэд, байгууллага, монголын баг тамирчдад биеийн тамирын чанартай үйлчилгээг үзүүлнэ.

Стратегийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

Зорилт-1:Биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхүйц спортын байгууламжийг бий болгож, спорт байгууламжийн орчин үеийн стандартыг нэвтрүүлнэ.

Зорилт-2:Монголын баг тамирчдад чанартай бэлтгэлийн орчноор үйлчилгээ үзүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт-3:Олон улс, тив, дэлхийн хэмжээний спортын наадам, фестивалийг зохион байгуулж, Монгол улсын нэр хүндийг олон улсын тавцанд гаргана.

Зорилт-4: Зорилтот бүлгийн иргэд, байгууллага, хамт олныг спортын хөтөлбөр, арга хэмжээгээр дэмжиж, нийгмийн эрүүл мэнд, идэвхтэй амьдралыг дэлгэрүүлнэ.

Зорилт-5:Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, стандарт, дүрэм, журмыг батлуулж, хэрэгжүүлэх үйл явцыг зохион байгуулна.

Зорилт-6:Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.